

Аудит хийгдсэн байгууллага:
ТӨВ АЙМГИЙН 27 СУМЫН СУМ
ХӨГЖҮҮЛЭХ САН

Огноо: 2022.04.16

ДОТООД АУДИТЫН НЭГЖ: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

Аудитын нэр: Төв аймгийн 27 сумын Сум хөгжүүлэх сангийн
үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит
Жил: 2021 он

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА : САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИЫН
АЛБА

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: ТӨВ АЙМГИЙН 27 СУМЫН СУМ ХӨГЖҮҮЛЭХ
САН

АУДИТЫН ТӨРӨЛ:

АУДИТЫН ХУГАЦАА : 2022.02.09 - 2022.04.16

Дотоод аудитын нэгжийн дарга : Б.САРУУЛ

Аудитын багийн ахлагч : И.БАТСАЙХАН

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

3. Байгууллагын сайн туршлага

3.1 Засаглалын удирдлагын талаар

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

3.3 Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

4.1 Илэрсэн асуудлын нэгтгэл

5 НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА:

Төв аймгийн 27 сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны үйл ажиллагаанд дотоод аудитыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны төлөвлөгөө, Аймгийн Засаг дарга бөгөөд Дотоод аудитын хорооны дарга Д.Мөнхбаатарын баталсан 33/07 тоот удирдамжийн дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3-т “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний Төсвийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит, Төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна” гэсэн заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-д заасан эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч И.Батсайхан хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитад:

1. Сумдын сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг Засгийн газрын 2016 оны 153 тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-уудын дагуу хөрөнгийг захиран зарцуулж байгаа эсэх.
2. Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчилд бичсэн акт, албан шаардлагын барагдуулалт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт, түүнийг арилгах давтан гаргахгүй байх чиглэлээр зохиосон ажил, үр дүн,
3. Сангуудын эх үүсвэрээр бий болсон үндсэн болон эргэлтийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал, ашиглалтын байдал
4. Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх, байгууллага хоорондын тооцоо нийлэлт
5. Төсөв хөрөнгийн эрх захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудын хууль, тогтоомжинд заасан эрх, үүргийн хэрэгжилтийн байдал
6. Сангуудын үйл ажиллагаатай холбоотой “Шилэн данс”-ны мэдээлэлд аудит хийх
7. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
8. Сангуудын нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэл, харилцах, касс, бараа материал зарцуулсан баримтын бүрдэлт,
9. Байгууллагын засаглал, эрсдлийн удирдлага болон дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөө, явц, тайлан хүрсэн үр дүнг үнэлэхэд чиглэгдлээ

Дотоод аудитын явцад Төв аймгийн 27 сумын сум хөгжүүлэх сангийн эх үүсвэр баталсан тогтоол, зээл хүү алдангийн тооцоолол, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийн гаргалт, болон анхан шатны баримт бүрдүүлэлтийг үндсэн баримттай тулган шалгаж гүйцэтгэлээ.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Сумдын Сум хөгжүүлэх сангийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үр нөлөөтэй байдлыг үнэлж, дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

- Удирдамжид заасан хамрах хугацаанд дотоод аудитад шаардлагатай баримтуудыг хамруулна.
- Төрийн аудитын болон бусад хяналт шалгалтын байцаагч нарын тухайн зөрчилд бичсэн акт, албан шаардлагыг давхардуулж бичихгүй байх.

- Аудитад хамрагдаагүй баримт, үйл ажиллагааг аудитын ажлын баримтанд тодорхой бичиж өгнө.

2.3 Аудитын арга, аргачлал:

Дотоод аудит хийхдээ Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ч.Цагаан, аудитор Г.Түмэнжаргал нар нь байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, дотоод хяналтын орчинтой танилцаж, орчны талаар болон байгууллагад тулгамдаж буй эрсдлийн талаар гүйцэтгэх удирдлагатай ярилцлага хийсэн. Санхүүгийн үйл ажиллагааны болон дотоод үйл ажиллагааны дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар нотлох зүйлд шалгалт хийлээ.

Мөн тус дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг ашиглалаа.

- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Монгол улсын төсвийн тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол улсын Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоол
- Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам
- Монгол улсын Засгийн газар, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас баталж гаргасан холбогдох эрх зүйн баримт бичгүүд.

3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

3.1 Засаглалын талаар:

Байгууллагын засаглалын бүтэц. Үүнд:

- Аймгийн Засаг дарга
- Аймгийн ЗДТГ-ын бүтцээс: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
- Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
- Гүйцэтгэх удирдлага: Сумдын Засаг дарга
- Хяналт шалгалт: Сумын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл
- Дотоод аудит- ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод аудит хийдэг.

Аймагийн Засаг даргын бүрэн эрх, үүрэг:

!“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-д зааснаар/

3.2.1. “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги” болон “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-тэй уялдуулан харьяалах нутаг дэвсгэртээ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;

3.2.2. аймгийн хэмжээнд сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн зохих журмын дагуу шийдвэрлэх;

3.2.3. аймгийн хэмжээнд сангаас олгосон зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, тайлан, мэдээг хянан баталгаажуулах, тэдгээрийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх;

3.2.4. харьяалах нутаг дэвсгэртээ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах;

3.2.5. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Гүйцэтгэх удирдлага: Сумдын засаг дарга

- 3.5.1. төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаанд сумын иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах;
- 3.5.2. энэ журамд заасны дагуу зээл олгох шийдвэр гаргах;
- 3.5.3. энэ журмын 3.5.2-т заасан төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах;
- 3.5.4. энэ журмын 3.5.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаанд бариулах хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх;
- 3.5.5. зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх;
- 3.5.6. сангийн орлого, зарлагыг хөтлөх үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг мөрдүүлж, сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
- 3.5.7. сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;
- 3.5.8. сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцах;
- 3.5.9. сумын иргэн, хуулийн этгээдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх болон бусад шаардлагатай асуудлаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх саналаа аймгийн Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх, иргэдийн дунд сургалт зохион байгуулж, оролцоог хангаж ажиллах.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар:

Тус ЭМТөв нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, тусдаа ажлын хэсэг, нэгж байгуулаагүй байна.

1. Байгууллагын стратеги, зорилго зорилтыг хангахад тулгарч буй гол эрсдлүүд:

- **Сум хөгжүүлэх сангийн программыг илүү боловсронгуй болгох шаардлагатай.**
- **Хугацаа хэтэрсэн зээлийн төлөлт муу байна**
- **Хяналтын тогтолцоо сул байна**

2. Гол эрсдэлийг бүртгэж, үнэлж, албажуулдаг уу?

Үгүй

3. Байгууллагын стратеги, зорилго зорилтыг хангахад сөргөөр нөлөөлөх гол эрсдэлийг бууруулах, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авдаг вэ?

- **Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээлдэг**
- **Хугацаа хэтэрсэн зээлийг шүүхийн байгууллагаар шийлвэрлүүлж барагдуулдаг**

4. Байгууллагад тулгарч байгаа эрсдэлийн талаар засаглах удирдлага болон байгууллагын бусад нэгж, ажилтнуудад мэдээлдэг үү?

Сум хөгжүүлэх сангийн тайлан мэдээг тухай бүр илгээдэг, Монгол банкны зээлийн мэдээллийг санг шинэчилдэг.

5. Тулгарч байгаа эрсдэл нь “эрсдэлийн дуршил (аппетит)”-аас доош хэмжээнд байгаа эсэхийг үнэлдэг үү?

Үгүй

6. Байгууллагад тулгамдаж байгаа мэдээллийн технологитой холбоотой эрсдэлтэй асуудал байгаа юу?

Сум хөгжүүлэх сангийн программыг илүү боловсронгуй болгох.

7. Байгууллагад тулгамдаж байгаа залилангийн эрсдэлтэй асуудал байгаа юу?

Байхгүй

8. Байгууллага залилангийн эрсдэлээс сэргийлэх тулд ямар арга хэмжээ авдаг вэ?
Үгүй
9. Дотоод аудитаар эрсдэлийн удирдлагын ямар асуудалд илүү анхаарал хандуулахыг хүсэж байна вэ? Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх талаар зөвлөгөө авахыг хүсэж байна.
Зээлийн эргэн төлөлт муу, хугацаа хэтэрсэн зээл их, хяналтын тогтолцоо сул байна. Сумдын сум хөгжүүлэх сангийн хүү алдангийн тооцоолол, санхүүгийн тайлагналд дүгнэлт гаргуулах, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлгэж, зөвлөн туслуулах

3.3 Дотоод хяналтын системийн талаар:

- ❖ Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт” Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг батлан мөрдөж ажилладаг. Дотоод хяналт хийх байгууллагын журмыг байгууллагын даргаар батлуулан мөрдсөн. Жил бүр төлөвлөгөө гаргаж ажилладаг. Байгууллагын даргын шийдвэрээр томилогдсон дотоод хяналтын 3 хүний бүрэлдхүүнтэй ажлын хэсэгтэй.
- ❖ Байгууллагын даргын тушаалаар томилогдсон дотоод хяналтын 5 хүний бүрэлдхүүнтэй зөвлөлтэй. Мөн 27 суманд сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажилладаг.

Байгууллагад бодитойгоор хэрэгжиж байгаа “урьдчилан сэргийлэх хяналт”

- СХСангаас олгосон зээлийн зориулалт, ашиглалт
- СХС-аас олгосон зээлийн үр дүн, эргэн төлөлт
- Монгол банкны зээлийн мэдээллийн сан

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ 4000

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эх үүсвэр:

- Төв аймгийн сумдын 2021 оны сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 3,680,734.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Эх үүсвэрийг хүснэгтээр харуулвал:

№	Сумын нэр	ИТХ-ын тогтоолын		Батлагдсан төсөв		
		Огноо	Дугаар	Зээл	Бусад зардалд	Нийт
1	Алтанбулаг	2020.10.17	5	200,000.0	1,500.0	201,500.0
2	Аргалант	2021.12.17	5	123,000.0	552.4	123,552.4
3	Архуст	2020.12.18	9	150,000.0	14,339.5	164,339.5
4	Батсүмбэр	2020.12.18	7	100,000.0	320.0	100,320.0
5	Баян	2020.12.17	8	210,000.0	5,791.3	215,791.3
6	Баяндэлгэр	2020.12.17	11	152,000.0	1,524.0	153,524.0
7	Баянжаргалан	2020.12.16	12	101,000.0		101,000.0
8	Баян-Өнжүүл	2020.12.18	7	120,000.0	2,228.2	122,228.2
9	Баянхангай	2020.12.18	4	100,000.0		100,000.0
10	Баянцогт	2020.12.18	8	80,000.0	660.0	80,660.0
11	Баянцагаан	2020.12.18	4	89,000.0	1,000.0	90,000.0
12	Баянчандмань	2020.12.18	3	162,804.8	3,195.2	166,000.0
13	Борнуур	2020.12.18	7	100,000.0	2,750.0	102,750.0
14	Бүрэн	2020.12.18	4	180,000.0	500.0	180,500.0
15	Дэлгэрхаан	2020.12.12	9	149,376	51,135.0	200,511.6
16	Жаргалант	2020.12.17	5	150,000.0	2,250.0	152,250.0
17	Заамар	2020.12.17	6	179,042.0	958.0	180,000.0
18	Зуунмод	2020.12.17	10	250,000.0	12,478.0	262,478.0
19	Лүн	2020.12.18	8	120,000.0	39,296.2	159,296.2
20	Мөнгөнморьт	2020.12.18	4	99,000.0	1,000.0	100,000.0
21	Өндөрширээт	2020.12.18	10	180,000.0		180,000.0
22	Сэргэлэн	2020.12.18	13	108,671.4	11,328.6	120,000.0
23	Сүмбэр	2020.12.18	8	60,000.0	534.0	60,534.0
24	Угтаалцайдам	2020.12.15	7	60,000.0	500.0	60,500.0
25	Цээл	2020.12.17	7	80,000.0	1,000.0	81,000.0
26	Эрдэнэ	2020.12.17	19	118,000.0	2,000.0	120,000.0
27	Эрдэнэсант	2020.12.20	9	100,000.0	2,000.0	102,000.0
Аймгийн дүн				3,521,894.0	158,840.4	3,680,734.4

Шинээр олгосон зээл:

Сум хөгжүүлэх сан нь 2021 онд нийт 22 сумын 219 иргэн аж, ахуйн нэгжид 2,046,055.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.

Сумын нэр	Алтанбулаг	Аргалант	Архуст	Батсүмбэр	Баяндэлгэр	Баянжаргалан	Баян-Өнжүүл	Баянхангай	Баянчандмань	Борнуур	Бүрэн	Дэлгэрхаан	Жаргалант	Заамар	Зуунмод	Лүн	Мөнгөнморьт	Өндөрширээт	Сэргэлэн	Сүмбэр	Эрдэнэ	Эрдэнэ	Нийт
Мөнгөн дүн	103,000	89,000	147,400	85,000	138,200	99,000	40,000	98,000	164,250	74,000	101,000	21,400	144,000	65,500	206,000	45,675	88,130	102,000	71,000	23,500	60,000	80,000	2,046,055
Хүний тоо	10	10	20	3	14	13	5	14	24	14	6	3	7	6	16	8	7	10	5	7	10	7	219

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ 4000

2021 оны эхэнд харилцах дансны эхний үлдэгдэл 943,893.6 мянган төгрөг, зээл, хүү алдангийн үлдэгдэл 8,543,531.5 мянган төгрөг нийт 9,487,425.1 мянган төгрөг байсан бол **2021 оны жилийн эцэст** харилцах дансны эхний үлдэгдэл 1,698,378.3 мянган төгрөг, зээл, хүү алдангийн үлдэгдэл 7,989,927.7 мянган төгрөг нийт 9,688,306.0 мянган төгрөг болсон байна.

№	Сумын нэр	2021 оны эхэнд			2021 оны жилийн эцэс		
		Харилцах С1	Зээлийн үлдэгдэл	Бүгд	Харилцах С2	Зээлийн үлдэгдэл	Бүгд
1	Алтанбулаг	60,079,669	295,793,558	355,873,227	128,901,387	237,937,805	366,839,192
2	Аргалант	63,069,861	300,748,642	363,818,503	87,774,576	282,425,398	370,199,973
3	Архуст	4,057,235	294,468,525	298,525,760	51,530,338	249,787,233	301,317,571
4	Батсүмбэр	37,315,586	360,317,541	397,633,127	94,959,362	312,936,860	407,896,222
5	Баян	82,321,801	212,984,147	295,305,948	160,603,372	143,930,055	304,533,427
6	Баяндэлгэр	49,652,324	267,818,731	317,471,055	55,324,490	280,307,581	335,632,071
7	Баянжаргалан	70,231,927	223,382,334	293,614,261	102,822,403	196,740,198	299,562,602
8	Баян-Өнжүүл	6,802,034	279,734,869	286,536,903	9,910,014	283,236,799	293,146,813
9	Баянхангай	10,122,570	246,424,518	256,547,088	6,324,100	251,877,142	258,201,242
10	Баянцогт	13,253,864	302,600,685	315,854,549	48,405,831	317,172,326	365,578,157
11	Баянцагаан	20,282,273	241,550,752	261,833,024	98,471,592	172,793,178	271,264,769
12	Баянчандмань	30,447,295	378,294,509	408,741,803	70,244,588	344,470,786	414,715,373
13	Борнуур	37,303,009	268,576,045	305,879,054	20,126,262	297,075,833	317,202,095
14	Бүрэн	42,204,333	296,382,117	338,586,450	100,646,796	252,100,815	352,747,611
15	Дэлгэрхаан	2,762,195	296,214,580	298,976,775	1,177,231	314,857,141	316,034,372
16	Жаргалант	38,889,365	340,702,939	379,592,304	77,953,216	312,964,303	390,917,519
17	Заамар	57,271,177	323,261,193	380,532,370	118,493,578	258,703,414	377,196,992
18	Зуунмод	5,329,438	1,214,305,376	1,219,634,814	18,474,794	1,224,008,904	1,242,483,698
19	Лүн	164,492	253,850,683	254,015,175	17,204,136	242,298,609	259,502,745
20	Мөнгөнморьт	6,378,845	325,479,335	331,858,180	13,285,506	339,328,961	352,614,467
21	Өндөрширээт	61,149,024	219,940,357	281,089,381	40,630,357	249,417,043	290,047,400
22	Сэргэлэн	89,954,865	229,261,038	319,215,904	142,658,459	172,265,849	314,924,308
23	Сүмбэр	1,175,459	284,070,952	285,246,411	8,619,439	288,924,379	297,543,818
24	Угтаалцайдам	12,161,383	251,064,066	263,225,449	85,353,858	188,732,098	274,085,956
25	Цээл	93,631,981	255,110,562	348,742,543	67,770,795	205,138,135	272,908,931
26	Эрдэнэ	33,396,872	322,910,007	356,306,879	40,529,795	322,910,007	363,439,803
27	Эрдэнэсант	14,484,730	258,283,407	272,768,137	30,182,039	247,586,817	277,768,856
Аймгийн дүн		943,893,606	8,543,531,468	9,487,425,073	1,698,378,313	7,989,927,671	9,688,305,984

Эрслийн үнэлгээ: Сум хөгжүүлэх санг сум болгонд 10

асуулгаар дүгнэж үзэхэд 81,3 хувьтай **ШААРДЛАГА ДУНД ХАНГАСАН** үнэлгээ авч байна.

№	Сумын нэр	Шалгуур үзүүлэлт										Дүн	Үнэлгээ
		СХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын тов, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг сумын	СХС-ийн журмын дагуу төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийг байгуулсан эсэх, төсөл сонгон шалгаруулсан	Зээлдэгчтэй зээлийн гэрээ байгуулсан эсэх	Зээлдэгчийн хувийн хэрэгт зээлийн барьцаа хөрөнгийн баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгалж, бүртгэл хөтөлсөн	СХС хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон	СХС-ийн зээлийн мэдээллийг мэдээллийн санд олмолсон байдал	Өмнөх оны СХС-д өгсөн акт албан шаардлагын хэрэгжилт, шалгалтаар илэрсэн зөрчил	Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, Санхүүгийн	Өглөг, авлагыг данс бүртгэлд бүрэн тусгаж, барагдуулсан байдал	Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлдэлтэй зээлдэгчдийг шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлсэн		
1	Алтанбулаг	10	10	10	10	5	10	10	10	10	0	85	Шаардлага бүрэн хангасан
2	Аргалант	10	10	10	5	0	10	10	5	5	5	70	Шаардлага дунд хангасан
3	Архуст	10	10	10	5	5	10	10	10	10	5	85	Шаардлага бүрэн хангасан
4	Батсүмбэр	10	10	10	5	0	10	10	10	10	10	85	Шаардлага бүрэн хангасан
5	Баян	10	10	10	10	5	5	10	10	10	10	90	Шаардлага бүрэн хангасан
6	Баяндэлгэр	10	10	10	5	0	10	10	10	10	0	75	Шаардлага дунд хангасан
7	Баянжаргалан	10	0	10	5	0	10	10	5	5	10	65	Шаардлага хангаагүй
8	Баян-Өнжүүл	10	10	10	5	5	10	10	5	5	5	75	Шаардлага дунд хангасан
9	Баянхангай	10	10	10	10	5	0	10	10	10	10	85	Шаардлага бүрэн хангасан
10	Баянцогт	10	10	10	5	10	10	10	10	5	10	90	Шаардлага бүрэн хангасан
11	Баянцагаан	10	10	10	10	0	5	10	10	5	10	80	Шаардлага дунд хангасан
12	Баянчандмань	10	10	10	10	5	10	10	10	10	10	95	Шаардлага бүрэн хангасан
13	Борнуур	10	10	10	5	0	10	10	5	5	10	75	Шаардлага дунд хангасан
14	Бүрэн	10	10	10	5	10	5	10	10	10	10	90	Шаардлага бүрэн хангасан
15	Дэлгэрхаан	10	0	10	5	0	5	10	5	5	5	55	Шаардлага хангаагүй
16	Жаргалант	10	10	10	10	5	10	10	10	5	5	85	Шаардлага бүрэн хангасан
17	Заамар	10	10	10	10	5	10	10	10	10	10	95	Шаардлага бүрэн хангасан
18	Зуунмод	10	10	10	10	10	5	5	5	5	10	80	Шаардлага дунд хангасан
19	Лүн	10	10	10	5	0	10	10	10	10	5	80	Шаардлага дунд хангасан
20	Мөнгөнморьт	10	10	10	10	0	5	10	5	5	0	65	Шаардлага хангаагүй
21	Өндөрширээт	10	10	10	5	10	10	10	10	5	5	85	Шаардлага бүрэн хангасан
22	Сэргэлэн	10	10	10	10	5	10	10	10	5	5	85	Шаардлага бүрэн хангасан
23	Сүмбэр	10	10	10	5	5	10	10	10	10	0	80	Шаардлага дунд хангасан
24	Угтаалцайдам	10	10	10	5	10	10	10	10	10	5	90	Шаардлага бүрэн хангасан
25	Цээл	10	10	10	10	0	10	10	10	10	10	90	Шаардлага бүрэн хангасан
26	Эрдэнэ	10	10	10	5	0	10	10	10	10	0	75	Шаардлага дунд хангасан
27	Эрдэнэсант	10	10	10	10	5	5	10	10	5	10	85	Шаардлага бүрэн хангасан
Аймгийн дүн		270	250	270	195	105	225	265	235	205	175	2,195.0	
Хувиар		100.0	92.6	100.0	72.2	38.9	83.3	98.1	87.0	75.9	64.8	81.3	ШААРДЛАГА ДУНД ХАНГАСАН

Өмнөх шалгалтын мөрөөр зохиосон ажил:

Сум хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтаар 20,957.0 мянган төгрөгний зөрчил илэрч үүнээс 957.0 мянган төгрөгийн зөрчилд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн акт 20,000.0 мянган төгрөгийн зөрчилд санхүүгийн хяналт шалгалтын албан шаардлага тогтоож ажилласан байна.

Зөрчил-1. Монгол банкны зээлийн мэдээлэл.

Сумдын сум хөгжүүлэх сангийн 2021 оны зээлийн үлдэгдэл Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн үлдэгдэл 579,458.8 сая төгрөгөөр зөрүүтэй мэдээлэгдсэн байна.

№	Сумын нэр	СХС-ийн зээлийн үлдэгдэл 2021.12.31-ны байдлаар		Монгол банкны мэдээллийн сан 2021.12.31-ны байдлаар		Мэдээлэлийн зөрүүтэй	
		Зээлдэгч ийн тоо	Бүгд	Зээлдэгч ийн тоо	Бүгд	Зээлдэгч ийн тоо	Бүгд
1	Алтанбулаг	29	237,937,805	28	210,285,741	1	27,652,064
2	Аргалант	70	282,425,398	47	232,187,844	23	50,237,554
3	Архуст	66	249,787,233	62	249,740,868	4	46,365
4	Батсүмбэр	23	312,936,860	23	299,231,899	-	13,704,961
5	Баян	13	143,930,055	10	108,322,127	3	35,607,928
6	Баяндэлгэр	66	280,307,581	47	278,507,227	19	1,800,354
7	Баянжаргалан	33	196,740,198	29	195,327,574	4	1,412,624
8	Баян-Өнжүүл	26	283,236,799	34	280,502,721	- 8	2,734,078
9	Баянхангай	52	251,877,142	45	252,991,560	7	- 1,114,418
10	Баянцогт	76	317,172,326	61	274,633,556	15	42,538,770
11	Баянцагаан	58	172,793,178	55	173,532,457	3	- 739,279
12	Баянчандмань	59	344,470,786	48	342,761,590	11	1,709,196
13	Борнуур	105	297,075,833	94	251,620,526	11	45,455,307
14	Бүрэн	41	252,100,815	41	286,861,945	-	- 34,761,130
15	Дэлгэрхаан	46	314,857,141	34	228,057,207	12	86,799,934
16	Жаргалант	85	312,964,303	46	297,791,719	39	15,172,584
17	Заамар	58	258,703,414	46	259,146,333	12	- 442,919
18	Зуунмод	183	1,224,008,904	180	1,029,719,847	3	194,289,057
19	Лүн	28	242,298,609	30	267,180,192	- 2	- 24,881,583
20	Мөнгөнморьт	92	339,328,961	57	245,616,015	35	93,712,946
21	Өндөрширээт	29	249,417,043	26	242,736,694	3	6,680,349
22	Сэргэлэн	28	172,265,849	13	114,366,784	15	57,899,065
23	Сүмбэр	111	288,924,379	84	204,340,351	27	84,584,028
24	Угтаалцайдам	36	188,732,098	34	201,704,441	2	- 12,972,343
25	Цээл	70	205,138,135	49	219,395,625	21	- 14,257,490
26	Эрдэнэ	97	322,910,007	89	327,802,123	8	- 4,892,116
27	Эрдэнэсант	28	247,586,817	27	336,103,957	1	- 88,517,140
Нийт		1,608	7,989,927,671	1,339	7,410,468,923	269	579,458,748

Зөрчил-2. Зөрчилд тогтоосон албан шаардлага

Сум хөгжүүлэх сан нь 2021 оны санхүүгийн тайланд 1,102,888.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү, алдангийг зөрүүтэй тооцож тайлагнасанд зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага тогтоосон.

№	Албан шаардлагын				Дүн
	Сар	№	Шалгагдсан байгууллагууд	Товч утга	
1	2022.03.10	33.08.09	Баянжаргалан сумын СХС	Зөрчил арилгуулах тухай	26,539.5
2	2022.03.15	33.04.13	Баянөнжүүл СХС	Зөрчил арилгуулах тухай	627.3
3	2022.03.15	33.08.14	Бүрэн сум СХС	Зөрчил арилгуулах тухай	5,303.6
4	2022.03.15	33.04.17	Баянөнжүүл сум СХС	Зөрчил арилгуулах тухай	627.3
5	2022.03.18	33.08.21	Баянцогт сум СХС	Зөрчил арилгуулах тухай	43,038.0
6	2022.03.18	33.04.23	Аргалант сум СХС	Зөрчил арилгуулах тухай	104,270.0
7	2022.03.23	33.02.24	Жаргалант сум СХС	Зөрчил арилгуулах тухай	8,340.8
8	2022.03.24	33.07.25	Борнуур сум СХС	Зөрчил арилгуулах тухай	316.8
9	2022.03.29	33.08.28	Баянцагаан сум СХС	Зөрчил арилгуулах тухай	133,693.8
10	2022.04.01	33.08.30	Дэлгэрхаан сум СХС	Зөрчил арилгуулах тухай	324,321.8
11	2022.04.04	33.08.31	Заамар сум СХС	Зөрчил арилгуулах тухай	1,678.6
12	2022.04.07	33.08.32	Мөнгөнморьт сум СХС	Зөрчил арилгуулах тухай	454,130.5
Нийт					1,102,888.0

Зөрчил-3. Хугацаа хэтэрсэн зээл

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлж, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлээгүйгээс нийт хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 805 иргэн 3,074,907.6 мянган төгрөг буюу нийт зээлийн 38,5 хувийг эзэлж байна.

Сумын нэр	Нийт зээл	Хугацаа хэтэрсэн зээл	
		Мөнгөн дүн	Хувь
Алтанбулаг	237,937,805	70,557,258	29.7
Аргалант	282,425,398	45,094,827	16.0
Архуст	249,787,233	56,570,862	22.6
Батсүмбэр	312,936,860	62,912,315	20.1
Баян	143,930,055	27,119,869	18.8
Баяндэлгэр	280,307,581	78,443,396	28.0
Баянжаргалан	196,740,198	23,866,287	12.1
Баян-Өнжүүл	283,236,799	179,100,501	63.2
Баянхангай	251,877,142	31,410,024	12.5
Баянцогт	317,172,326	161,341,210	50.9
Баянцагаан	172,793,178	133,055,112	77.0
Баянчандмань	344,470,786	7,414,064	2.2
Борнуур	297,075,833	192,178,216	64.7
Бүрэн	252,100,815	43,147,971	17.1
Дэлгэрхаан	314,857,141	251,616,995	79.9
Жаргалант	312,964,303	94,341,540	30.1
Заамар	258,703,414	104,035,298	40.2
Зуунмод	1,224,008,904	469,818,253	38.4
Лүн	242,298,609	101,880,350	42.0
Мөнгөнморьт	339,328,961	192,431,626	56.7
Өндөрширээт	249,417,043	69,675,354	27.9
Сэргэлэн	172,265,849	10,758,090	6.2
Сүмбэр	288,924,379	237,466,180	82.2
Угтаалцайдам	188,732,098	174,865,385	92.7
Цээл	205,138,135	78,804,886	38.4
Эрдэнэ	322,910,007	159,814,521	49.5
Эрдэнэсант	247,586,817	17,187,261	6.9
Аймгийн дүн	7,989,927,671	3,074,907,650	38.5

4. ИЛЭРСЭН АСУУДЛЫН НЭГТГЭЛ

Сум хөгжүүлэх сан нь 2021 онд 27 сумын 23 сум нь буюу 85,2 хувь нь Зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөл ажиллаагүй, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх дараагийн арга хэмжээ аваагүй 16 сум буюу 59,3 хувь, Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл зөрүүтэй мэдээлсэн 24 сум буюу 88,9 хувь, зээлдэгчүүдийн барьцаа хөрөнгийн гэрчилгээ дутуу, бүртгэлжүүлээгүй 9 сум буюу 33,3 хувь, Зээлдэгчийн зээлийн хүү алдангийн илүү, дутуу тооцсон 9 сум буюу 33,3 хувь, Өр, авлагыг барагдуулаагүй, санхүүгийн тайланд тусгаагүй 4 сум буюу 14,8 хувийг тус тус эзэлж байна.

Сумын нэр	Илэрсэн асуудлууд						Нийт
	Зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөл ажиллаагүй	Хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх дараагийн арга хэмжээ аваагүй	Зээлдэгчүүдийн барьцаа хөрөнгийн гэрчилгээ дутуу, бүртгэлжүүлээгүй	Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл зөрүүтэй мэдээлсэн	Зээлдэгчийн зээлийн хүү алдангийн илүү, дутуу тооцсон	Өр, авлагыг барагдуулаагүй, санхүүгийн тайланд тусгаагүй	
Алтанбулаг	1	1		1			3
Аргалант	1	1	1	1	1	1	6
Архуст	1		1	1			3
Батсүмбэр	1	1		1			3
Баян	1			1			2
Баяндэлгэр	1	1	1	1			4
Баянжаргалан	1	1		1	1		4
Баян-Өнжүүл			1	1	1		3
Баянхангай	1			1			2
Баянцогт	1	1		1	1		4
Баянцагаан	1				1		2
Баянчандмань	1			1			2
Борнуур	1	1	1	1		1	5
Бүрэн	1			1			2
Дэлгэрхаан	1	1		1	1		4
Жаргалант	1	1		1		1	4
Заамар					1		1
Зуунмод	1			1	1		3
Лүн	1	1	1				3
Мөнгөнморьт	1	1		1	1		4
Өндөрширээт		1	1	1			3
Сэргэлэн	1			1			2
Сүмбэр		1	1	1		1	4
Угтаалцайдам	1	1		1			3
Цээл	1	1		1			3
Эрдэнэ	1	1	1	1			4
Эрдэнэсант	1			1			2
Нийт	23	16	9	24	9	4	85

5. ЗӨВЛӨМЖ

1. Хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлж хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах.
 2. Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл, могол банкны мэдээллийн санг тулган баталгаажуулалт хийж зөрүүг арилгах
 3. Зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн ажлыг эрчимжүүлж хугацаа хэтэрсэн зээлийг төлж барагдуулах ажилд оролцуулах
 4. Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодогч нар сар бүр зээлдэгч тус бүрээр тооцоо нийлж тулган баталгаажуулалт хийж байх
- Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сард багтаан арилгаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан тоотой хариу мэдэгдэх.

6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

Дотоод аудитаар 81,3 хувь буюу “ШААРДЛАГА ДУНД ХАНГАСАН” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Шаардлага дунд хангасан	❖ Засаглалын төлөвшлийн түвшний үнэлгээ “2-р түвшин буюу томьёолсон ❖ Эрсдлийн удирдлагын төлөвшлийн үнэлгээ нь “Давтамжтай буюу 2-р түвшин”-д ❖ Дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “1-р түвшин буюу Эхлэлийн” түвшинд Аудитаар илэрсэн асуудлын 19-81 хувь нь “ нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
СХШ-ЫН УЛСЫН БАЙЦААГЧ И.БАТСАЙХАН

ТАЙЛАН ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА Б.САРУУЛ

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ХХААГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ГАНТУЛГА
ҮХҮА-НЫ ДАРГА Б.ЛХАГВАСҮРЭН